

Дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал

2017 он 4-р сар

АГУУЛГА

Хуудасны
дугаар

1. ДҮҮРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2
2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	3
3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	6
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	7
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	8
6. НИЙГМИЙН ДААТГАЛ	9
7. НИЙГМИЙН ХАЛАМЖ	10
8. УЛААН ЗАГАЛМАЙ	11
9. АХМАДЫН ХОРОО	11
10. АЖ АХУЙН НЭГЖ	12
11. АЖ ҮЙЛДВЭР	13
12. ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	14
13. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ	15
14. ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	15
15. ЗАХИРГААНЫ МЭДЭЭ	16
16. ГЭМТ ХЭРЭГ	17
17. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ЗӨРЧИЛ	17
18. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ ГАМШИГ	18
19. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ	18
20. СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	19
21. ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ	19

Хүснэгт 1. Дүүргийн үндсэн үзүүлэлт. 2017 оны 4 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 он	2017 он
Суурин хүн ам /жилийн эцэст/	Хүн	154819	158014
Төрөлт	Тоо	1320	1163
Шинээр төрсөн хүүхэд	Тоо	1335	1167
Нас баралт	Тоо	244	275
Халдварт өвчин	Тоо	2140	1005
Ажилгүйчүүд	Хүн	2228	2066
Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	901	829
Дүүргийн төсвийн орлого	Сая төгрөг	21407.4	36523.2
Дүүргийн төсвийн зарлага	Сая төгрөг	19693.4	22058.4
Валютын ханш	1US\$=₮	2012	2419




ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 4-р сарын Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6 хувиар, 2016 оны жилийн эцэстэй харьцуулахад 5.2 хувиар, өмнөх сартай харьцуулахад 1.5 хувиар тус тус өссөн байна..

Хүснэгт 2. Хэрэглээний үнийн индекс

Бараа үйлчилгээний бүлэг	2015.04 2014.04	2016.04 2015.04	2017.04 2016.12	2017.04 2017.03
Ерөнхий индекс	101.9	103.6	105.2	101.5
Хүнсний бараа, ундаа, ус	99.0	104.4	114.8	103.2
Согтууруулах ундаа, тамхи	101.9	102.2	101.1	99.6
Хувцас, бөс бараа	101.2	100.8	99.8	100.7
Орон сууц, ус, түлш, цахилгаан	100.1	104.6	99.4	99.3
Гэр ахуйн тавилга, бараа	102.9	102.3	100.9	100.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	107.3	105.2	102.5	101.8
Тээвэр	97.2	107.8	106.5	102.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	99.7	100.7	99.9
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	99.6	100.1	102.1	102.0
Боловсролын үйлчилгээ	123.6	102.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	101.8	98.9	97.7	100.9
Бусад бараа, үйлчилгээ	103.8	104.7	102.0	101.1

Зураг 1. Хэрэглээний үнийн өсөлт сараар



Хэрэглээний үнийн индекс 2017 оны 4-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 5.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 14.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 1.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бүлгийн үнэ 0.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 2.5 хувь, тээврийн үйлчилгээ 6,5 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ 0,7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 2,1 хувь, бусад бараа, үйлчилгээ 2,0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


Хүснэгт 3. Бараа бүтээгдэхүүний дундаж үнэ, төгрөг

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2015.04	2016.04	2017.04
Алтан тариа 1-р зэрэг	кг	995	1065	980
Атар талх	ш	1080	1150	1170
Цагаан будаа	кг	2365	2510	2645
Шар будаа	кг	1795	1695	1780
Хонины мах /ястай/	кг	7955	7380	7375
Үхрийн мах /ястай/	кг	7355	8730	7920
Адууны мах	Кг	5975	5650	6675
Тахианы гуя	кг	6600	6500	6500
Сүү задгай	л	900	925	1010
Цөцгийн тос /Сүү ХХК/	кг	3005	3255	3290
Өндөг	ш	305	285	330
Ургамлын тос /Янга/	л	2967	3300	3460
Алим, кг	кг	4245	4035	4300
Банан, шар	кг	4500	5000	5000
Төмс	кг	1300	1075	675
Лууван	кг	1425	1975	900
Сонгино	кг	1200	1310	1490
Элсэн чихэр	кг	1750	1785	2560
Цэвэр усны үнэ тоолуургүй 1хүний	хүн	4705.8	4705.8	4705.8
Эдийн саван ОК	ш	600	700	750
Угаалгын нунтаг "ОМО"	ш	800	850	1100
Аяга, таваг угаагч шингэн, "Fairy"	ш	3600	4050	4300

Зураг 2. Алтан тариа дээд гурил, атар талхны үнэ, 2013-2017 он




Зураг 3. Нэг кг хонь, үхрийн махны дундаж үнэ, 2012-2017 он



2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04 2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04

Зураг 4. Нэг кг лууван, төмсний дундаж үнэ, 2012-2017 он



2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04 2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04

Зураг 5. Нэг кг сонгино, байцааны дундаж үнэ, 2012-2017 он



2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04 2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04

Зураг 6. Шатахууны үнэ, 2012-2017 он



2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04 2012.04 2013.04 2014.04 2015.04 2016.04 2017.04



ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого: Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2017 оны 4 дүгээр сарын байдлаар 36 523.2 сая төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн дүн 22 058.4 сая төгрөг болж, орон нутгийн төсвийн нийт тэнцэл 14 464.8 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.

Орон нутгийн нийт төсвийн төлөвлөгөөний биелэлтийг нэр тус бүрээр нь доорх хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 4. Төсвийн урсгал орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт орлогын дүн	27 070 848.6	36 523 209.6	9 452 361.0	34.9
Урсгал орлого	14 126 210.4	23 593 727.5	9 467 517.1	67.0
1. Татварын орлого	13 851 560.4	22 010 670.7	8 159 110.3	58.9
Орлогын албан татвар	4 738 035.8	3 934 549.7	-803 486.1	16.9
Өмчийн татвар	8 285.0	8 286.3	1.3	0.02
Бусад татвар	9 105 239.6	18 067 834.7	8 962 595.1	98.4
2.Татварын бус орлого	274 650.0	1 583 056.8	1 308 406.8	476.4
Тусламжийн орлого	12 944 638.2	12 929 482.1	-15 156.1	0.1

Төсвийн төлөвлөгөөний биелэлт тусламжийн орлогоос бусад нэр төрөл дээр төлөвлөснөөс давж бүрдсэн байна.

Төсвийн зарлага:

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 2017 оны 4 дүгээр сарын байдлаар 22 058.4 сая төгрөг болж төлөвлөсөн хэмжээнээс 9 949.4 сая төгрөгөөр буюу 31.1 хувиар төсвийн зардлыг хэмнэсэн байна.

Зураг 7. Төсвийн зардал



Төсвийн нийт зарлагын 31.7 хувийг цалин хөлс, 3.5 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 40.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 23.1 хувийг татаас, 0.8 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Төсвийн зарлага


Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /мян.төг/	Биелэлт
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	32 007 863.8	22 058 420.8	-9 949 443.0	31.1
А. Урсгал зардлын дүн	29 531 100.4	21 879 336.2	-7 651 764.2	25.9
1. Бараа үйлчилгээний зардал	23 522 332.2	16 778 312.5	-6 744 019.7	28.7
1.1 Цалин хөлс	7 796 591.1	6 983 655.1	-812 936.0	10.4
1.2 НДШ хураамж	870 372.9	768 405.5	-101 967.4	11.7
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	14 855 368.2	9 026 251.9	-5 829 116.3	39.2
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0.0	0.0	0.0	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	6 008 768.2	5 101 023.7	-907 744.5	15.1
3.1 Татаас	6 008 768.2	5 101 023.7	-907 744.5	15.1
3.2 Урсгал шилжүүлэг	0.0	0.0	0.0	-
Б. Хөрөнгийн зардал	2 476 763.4	179 084.6	-2 297 678.8	92.8
1. Хөрөнгө оруулалт	2 476 763.4	179 084.6	-2 297 678.8	92.8



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн хэлтсийн 2017 оны 4-р сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй 2066 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 974 буюу 47.1 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 16 буюу 0.8 хувь байна. Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 189 буюу 9.1 хувь нь 15-24 насны, 854 буюу 41.3 хувь нь 25-34 насны, 548 буюу 26.5 хувь нь 35-44 насны, 361 буюу 17.5 хувь нь 45-54 насны, 114 буюу 5.6 хувь нь 55 дээш насны хүмүүс байна.

Зураг 8. Ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо боловсролын түвшингээр





ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн мэдээгээр 2017 оны 4 дүгээр сарын байдлаар дүүргийн хэмжээнд 1163 эх амаржиж, 1167 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эхийн тоо 157 буюу 11.9 хувь, амьд төрсөн хүүхэд 168 буюу 12.6 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6. Эмнэлгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт		2016 он	2017 он	Зөрүү	Хувь
Нийт үзлэг		258 038	246 241	-11 797	4.6
Үүнээс:	Урьдчилан сэргийлэх	92 559	93 876	1 317	1.4
	Амбулаторид	81 211	72 722	-8 489	10.5
	Диспансерийн хяналт	32 451	29 926	-2 525	7.8
	Гэрийн үзлэг	50 118	42 649	-7 469	14.9
	Гэрийн дуудлагын үзлэг	1 699	7 068	5 369	316.0
Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг		90 645	82 895	-7 750	8.5
Өрхийн эмчийн үзлэг		167 393	163 346	-4 047	2.4
Бүртгэгдсэн өвчлөл		17 146	21 587	4 441	25.9
Үүнээс:	Шинэ	11 338	14 135	2 797	24.7
	Хуучин	5 808	7 452	1 644	28.3
Бүртгэгдсэн хорт хавдар		22	20	-2	9.1
Осол гэмтэл		308	18	-290	94.2
Хэвтсэн өвчтөн		3 767	3 201	-566	15.0
Эмнэлгийн нас баралт		19	21	2	10.5
Хоног болоогүй нас баралт		2	4	2	100.0
Эмчлэгдсэн өвчтөн		3 747	3 233	-514	13.7
Түргэн тусламжийн дуудлана		1 445	1 445	0.0	0.0

2017 он гарсаар 275 хүн нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс 31 хүнээр буюу 12.7 хувиар өссөн байна. Нийт нас баралтын дотор нялхсын эндэгдэл 11 буюу 4.0 хувь, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн байна. Нялхсын эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 47.6 хувиар буурсан байна. 2017 оны эхний 4 сарын байдлаар 246.2 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 11.8 мянган хүн буюу 4.6 хувиар, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний хүний тоо 3201 болж өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 9. Нийт үзлэг, төрлөөр



Хүснэгт 7. Халдварт өвчин

Үзүүлэлт	2016 он	2017 он	Зөрүү	Хувь
Халдварт өвчин	2140	1005	-1135	53.0
Гепатит	10	12	2	20.0
Цусан суулга	42	63	21	50.0
Сальмоннез	1	8	7	700.0
Хоолны хордлого	0	0	0	-
Менингит	0	1	1	-
Салхин цэцэг	118	232	114	96.6
Гахайн хавдар	8	4	-4	50.0
Улаан эсэргэнэ	35	54	19	54.3
Ёлом	1	7	6	600.0
Улаан бурхан	1371	0	-1371	100.0
Улаанууд	0	0	0	-
Бруцеллёз	1	2	1	100.0
Гар, хөл, ам	142	241	99	69.7
Тэмбүү	181	127	-54	29.8
Төрөлхийн тэмбүү	1	0	-1	100.0
Заг хүйтэн	74	41	-33	44.6
Трихомониаз	26	53	27	103.8
Мөөгөнцөр	15	11	-4	26.7
Сүрьеэ	109	109	0	-
Бусад	6	5	-1	16.7

Халдварт бус өвчин 2017 оны эхний 4 сарын байдлаар 21.6 мянга бүртгэгдсэн нь өмнөх оноос 25.9 хувиар өссөн байна. Халдварт өвчин 1005 бүртгэгдсэн нь өмнөх оноос 53 хувиар буурсан нь улаан бурхан өвчний бууралттай холбоотой байна. Бэлгийн замын халдварт өвчин нийт халдварт өвчний 23.1 хувийг эзэлж байна. БЗХӨ өнгөрсөн оны мөн үеэс 21.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



НИЙГМИЙН ДААТГАЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 4-р сард төсвийн 200 байгууллагын 18318 албан хаагчид, хувийн хэвшлийн 3537 аж ахуйн нэгжийн 69194 албан хаагчид, сайн дурын 9607 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Эрүүл мэндийн даатгалд 43471 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн даатгалыг хариуцсан даатгуулагч 34783 байна.

Хүснэгт 8. Тэтгэвэр олголт

	Хүний тоо	Олгосон тэтгэмж	
		Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Өндөр настан	15887	22911.9	22410.5
Тахир дутуу	3079	3248.9	3013.9
Тэжээгчээ алдсан	968	904.9	956.2
Дүн	19934	27065.7	26380.6



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 4-р сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 13.5 хувийг жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 2.2 хувийг хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлогод тус тус хуваарилсан байна.

Хүснэгт 9. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, сая.төг

Үзүүлэлт	Үнийн дүн
Нийгмийн халамжийн сангийн орлого	4934.8
1. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн төсвийн санхүүжилт	2569.2
а) Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	730.3
б) Алдарт эхийн одонгийн тусламж	1100.0
с) Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	639.0
д) ОНОТХҮ үйлчилгээний санхүүжилтын орлого	-
е) Хүнс тэжээл хөтөлбөрийн дансны санхүүжилтын орлого	99.9
2. Нийгмийн халамжийн сан	2365.6
а) Төсвийн санхүүжилтын орлого	2362.9
б) Бусад орлого	
3. Хүүгийн орлого	2.7
Зарлагын нийт дүн	3902.6
1. Нийгмийн халамжийн сан	2230.7
2. Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж	458.1
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1017.5
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	101.9
5. Хүнс тэжээлийн хөтөлбөр	94.4
6. ОНОТХ. үйлчилгээ	-

Нийгмийн халамжийн сан нь 2570 хүнд халамжийн тэтгэвэр, 4516 хүнд асаргааны мөнгөн тэтгэмж, 3550 хүнд ахмад настаны хөнгөлөлт тусламж, 5012 хүнд жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй эхийн мөнгөн тэтгэмжийг зарцуулсан байна.



УЛААН ЗАГАЛМАЙН ЧИГЛЭЛЭЭР

Дүүргийн “Улаан загалмайн хороо” 2017 оны 4-р сард нийт 43 хүнд 913.4 мян.төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40 хүн, 694.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүн зардалаар

Үзүүлэлт	2016 он 04-р сар			2017 он 04-р сар		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг /
Халамж үйлчилгээ	8	83	1607600	4	43	913400
Халамжийн чиглэлээрх сургалт,сурталчилгаа	3	107		4	66	
Анхны тусламжийн сургалт	13	330		19	308	
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	5	422		2	96	
Гамшгийн тусламж	1	6	105000	2	9	313000
Гамшгийн талаарх сургалт, суртчилгаа	1	136		3	36	
Донорын өдөрлөг	2	503		1	17	
Дүн	33	1587	1712600	35	575	1226400

Мөн анхы тусламжийн 19 удаагийн сургалт зохион байгуулж, сургалтанд нийт 308 иргэн, халамжийн чиглэлээрх сургалт, суртчилгаа 19 удаа, 308 иргэн,эрүүл мэндийг дэмжих сургалт,суртчилгаа 2 удаа,96 иргэн, гамшгийн талаарх сургалт,суртчилгаа 3 удаа 36 иргэн, донорын өдөрлөг арга хэмжээг 1 удаа зохион байгуулж 17 иргэнийг тус, тус хамруулсан байна.

АХМАДЫН ХОРОО

2016 оны ажлаараа Улсын тэргүүний анхан шатны нэгжээр шалгарсан мөн дүүргийн 2 удаагийн Тэргүүний 19 дүгээр хорооны Ахмадын зөвлөлийн ажилтай Монголын Ахмадын холбоо, Нийслэлийн Ахмадын хорооны удирдах ажилтнууд 2017.04.28-ны өдөр газар очиж танилцлаа. Герентологийн үндэсний төвтэй хамтран 2017.04.27-ны өдөр ЭМЯ-ны “Б” танхимд “Эрүүл насжилтын төлөө хамтдаа” сайн дурын идэвхитний давтан сургалтанд 30 хүнийг оролцуулсан. Хамрагдсан хүмүүст гэрчилгээ олгосон. Ахмадын хорооны даргын тушаалаар олон ам бүлтэй, эмчилгээний зардал хүссэн 3 ахмад настанд тус бүр 100,000 нийт 300,000 мянган төгрөгийн тусламжийг олголоо.

Монгол зурхайн Түвдэнпэлжээлин хийдтэй хамтран “Өглөгийн өдөр” арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. 2017.04.20-нд зохион байгуулсан “Өглөгийн өдөр” арга хэмжээнд 1 хорооноос 8 нийт 152 ахмадад хүнсний тусламж үзүүлж, заслын ном хурууллаа. Монгол зурхайн Түвдэнпэлжээлин хийдтэй хамтран “Өглөгийн өдөр” арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай. 2017.04.20-нд зохион байгуулсан “Өглөгийн өдөр” арга хэмжээнд 1 хорооноос 8 нийт 152 ахмадад хүнсний тусламж үзүүлж, заслын ном хурууллаа. 12 дугаар хорооны Ахмадын зөвлөлөөс санаачлан Улан-Үдэ, Итгэлт хамба болон Рэнбүүчийн сүмд мөргөл үйлдүүлж, байгалийн сайханд хамт олноороо 32 ахмад настан аялан амарсан. Дүүргийн ИТХ, ЗДТГ-аас 2017 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан. Эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд Ахмадын хорооноос 19 хорооны ахмадын зөвлөлийн дарга нар нийт 22 хүнийг “Сөүл” эмнэлэгтэй хамтран эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношлогоонд оруулсан. Ахмадын хорооны даргын тушаалаар үзлэг оношлогооны зардлыг гаргасан. Дүүргийн ИТХ-ын Ажлын албанаас 4 дүгээр сарыг “Эрүүл мэндээ хамгаалах сарын аян”-ыг зарласан. Аяны хүрээнд хороодод тодорхой төлөвлөгөөний дагуу олон төрлийн ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна. Ахмадууд болон иргэд өглөө бүр хорооныхоо Чийрэгжүүлэх болон Иргэний танхимд өглөөний дасгал, хийн болон аэробекийн дасгал, бүжиг хийж, тоглоом наадгайнд идэвхитэй оролцож чөлөөт цагаа өнгөрүүлж байна. Давхардсан тоогоор өглөөний дасгалд 200 гаруй, бариа засалд 35, шарлага 46, зөв хоололтын сургалтанд 142, цэнгээнт нийтийн бүжигт 240 гаруй ахмад настан тус тус хамрагдаад байна Тайлангийн хугацаанд эрүүл мэндийн сургалтанд 172, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ оношлогоо, урьдчилан сэргийлэх үзлэгт 193 ахмад настан хамрагдсан. Монголын бүх ард түмний спортын ХҮ их наадам, Чингэлтэй дүүргийн 25 жилийн ой, Эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд дүүргийн ахмадын аварга шалгаруулах тэмцээн спортын 9 төрлөөр буюу 2016.04.14-ээс 5 дугаар сарын 18 хүртэл үргэлжлэн явагдаж байна.



АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО

2017 оны 4 дүгээр сарын байдлаар татварын хэлтсийн мэдээлэл боловсруулалтын санд бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 16226 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.2 хувиар буюу 1086 аж ахуй нэгж байгууллагаар нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагын 77.1 хувь буюу 12503 байгууллага нь ХХК байна. Он гарсаар 317 аж ахуйн нэгж байгууллага нэмэгдэж, 3 байгууллага сангаас хасагдсан байна.

Хүснэгт 11. Аж ахуй нэгж байгууллагын тоо

ААНБ-ын төрөл	ААНБ-ын хариуцлагын хэлбэр	2015.04	2016.04	2017.04
ААН	ХК	9	11	14
	ХХК	11185	11716	12503
	ББН	115	124	129
	ЗБН	85	88	96
	ХХН	30	41	52
	Хоршоо	55	48	48
	Хадгаламж зээлийн хоршоо	67	59	60
	Төрийн өмчит үйлдвэрийн газар	30	33	33
	ОНӨҮГ	7	11	13
	Салбар	725	718	747
	Төлөөлөгчийн газар	8	19	24
	Төлөөний газар	1	2	4
	Боловсролын сургалтын байгууллага		1	1
	Нийт	12317	12871	13724
Төсөв болон ТББ	Төсөвт байгууллага	263	278	299
	Төрийн бүс байгууллага	1435	1643	1839
	Шашны байгууллага	40	42	42
	Сан	87	101	114
	Олон нийтийн байгууллага	198	205	208
	Нийт	2023	2269	2502
Бүгд		14340	15140	16226



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны 4 сард 1468.9 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35.7 хувь буюу 524.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь хувцас үйлдвэрлэл 28.8 хувь, хүнс үйлдвэрлэл 73.2 хувь, хэвлэлийн үйлдвэрлэл 32.7 хувь, бусад үйлдвэрлэл 22.0 хувиар тус тус өсөхөд нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 12. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /сая.төг/

Салбар		2016.04	2017.04	Өсөлт, бууралт	Зөрүү
Бүгд		944	1468.9	35.7	524.9
Үүнээс:	Хувцас үйлдвэрлэл	346.2	486.6	28.8	140.4
	Хүнс үйлдвэрлэл	53.1	198.1	73.2	145.0
	Хэвлэлийн үйлдвэрлэл	419.0	622.9	32.7	203.9
	Бусад үйлдвэрлэл	125.7	161.3	22.0	35.6

2017 оны 4 дугаар сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн 33.1 хувийг хувцас үйлдвэрлэл, 13.5 хувийг хүнс үйлдвэрлэл, 42.4 хувийг хэвлэлийн үйлдвэрлэл, 11.0 хувийг боловсруулах салбарын бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Зураг 10. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн



ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэний бүртгэлийн үйлчилгээ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2017 оны 4-р сарын байдлаар иргэний бүртгэлийн 8 төрлийн үйлчилгээг 3772 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1,4 хувиар, өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 13. Иргэний бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт		2016.04	2017.04
Нийт		2565	3772
Шинэ төрсөн		275	313
Гэрлэлт		70	89
Гэр бүл цуцлалт		24	26
Хүүхэд үрчлэлт		2	8
Эцэг тогтоосон		130	148
Овог, нэр өөрчлөх		9	14
Иргэний үнэмлэх олголт	16 нас хүрч шинээр авсан	147	212
	дахин олголт	395	440
Шилжилт хөдөлгөөн	шилжин ирсэн	626	1107
	шилжин явсан	887	1415

Эд хөрөнгийн бүртгэл үйлчилгээ:

Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэс нь 2017 оны 4-р сарын байдлаар 1958 иргэн, аж ахуй нэгж байгууллагад эд хөрөнгийн бүртгэлийн 5 төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүснэгт 14. Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээ

Үзүүлэлт	Үйлчлүүлсэн тоо			Үйлчилгээний хөлс /мян.төг/		
	Нийт	Газар	Газраас бусад	Нийт	Газар	Газраас бусад
Нийт	1958	778	1180	34646.5	5148.4	29498.1
Анхны бүртгэл	98	35	63	339.9	30.0	309.9
Өмчлөх эрх шилжих гэрээ	321	125	196	8788.0	2968.0	4820.0
Барьцааны гэрээ	1301	543	758	24334.1	1454.4	22879.7
Бусад гэрээ	1	-	1	10.0	-	10.0
Лавлагаа, хуулбар	194	52	142	1634.5	396.0	1238.5
Бүртгэлд өөрчлөлт оруулах	43	23	20	540.0	300.0	240.0

ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 4 дүгээр сарын байдлаар 4501.6 мян.м² зам талбай цэвэрлэж, 16.8 мян.м² хог тээвэрлэсэн байна. Өнгөрсөн оноос цэвэрлэсэн талбай 1072.5 мян.м² буюу 46.6 хувиар нэмэгдэж, харин тээвэрлэсэн хог 10.7 мян.м³ буюу 38.9 хувиар буурсан байна. Ажил үйлчилгээний орлого 945.3 сая төгрөг болж өнгөрсөн оноос 633.2 сая төгрөг буюу 40.1 хувиар буурсан байна. Орлогын эх үүсвэрийг ангилвал 9.2 хувийг зам талбай, 40.9 хувийг гэр хорооллоос, 22.7 хувийг орон сууцнаас, 27.2 хувийг албан газраас тус тус олсон орлого эзэлж байна.

Хүснэгт 15. Тохижилтын ажил

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2016.4	2017.4	Зөрүү	%
Цэвэрлэсэн талбай		мян.м ²	2939.9	4501.6	1561.7	53.1
Тээвэрлэсэн хог		мян.м ³	37.7	28.3	-9.4	
Үүнээс:	Орон сууц	мян.м ³	9.4	7.2	-2.2	
	Гэр хороолол	мян.м ³	17.0	12.7	-4.3	
	Албан газар	мян.м ³	5.7	4.2	-1.5	
	Зам талбай	мян.м ³	5.7	4.2	-1.5	
Ажил үйлчилгээний орлого		сая.төг	2153.1	1031.1	-1122.0	52.1
Үүнээс:	Зам талбай	сая.төг	388.0	86.9	-301.1	77.6
	Гэр хороолол	сая.төг	794.3	386.3	-408.0	51.4
	Орон сууц	сая.төг	441.3	300.4	-140.9	31.9
	Албан газар	сая.төг	529.5	257.5	-272.0	51.4

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2017 оны 04 сарын байдлаар дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 200 өргөдөл, гомдол ирснээс 121-г хуулинд заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй, шийдвэрлэх шатандаа явж байгаа 79 өргөдөл, гомдол хянагдаж байна.

Хүснэгт 20. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Ангилал	НИЙТ	Шийдвэрлэх шатандаа байгаа			Шийдвэрлэж хариу өгсөн		
		Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд	Хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	Бүгд
1800-1200 тусгай дугаарын утас	6	2	0	2	4	0	4
www.ub1200.mn цахим хуудас	5	2	0	2	3	0	3
Засгийн газрын 11-11 төв	11	2	0	2	9	0	9
Иргэд хүлээн авах төв	25	16	0	16	9	0	9
Нутгийн захиргааны байгууллагууд	0	0	0	0	0	0	0
Smart UB аппликейшн, Clean UB аппликейшн	0	0	0	0	0	0	0
Мессеж	0	0	0	0	0	0	0
Шуурхай удирдлага, зохицуулалтын төв	153	57	0	57	96	0	96
НИЙТ	200	79	0	79	121	0	121



ОСОЛ, ГЭМТ ХЭРЭГ

2017 оны 04 сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 829 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 72 тохиолдлоор буурсан байна.

Хүснэгт 17. Гэмт хэрэг

Төрөл		Цагдаагийн I хэлтэст бүртгэгдсэн				Цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн			
		2016.04	2017.04	Илрүүлэлтийн хувь	Хувь/%/	2016.04	2017.04	Илрүүлэлтийн хувь	Хувь/%/
Хэргийн ангилал	Хөнгөн	281	249	56.3	-1.4	115	129	77.4	12.2
	Хүндэвтэр	215	184	50	-14.4	226	221	41.4	2.4
	Хүнд	29	24	72.7	-17.2	15	16	88.9	11.1
	Онц хүнд	11	16	100	45.4	9	0		-100
Гэмт хэргийн төрөл	Хүн амь		2	100		5	0		-100
	Учрал	6	2		-66.7	4	4		
	Залилан	94	106	60.8	12.8	17	13	42.9	42.8
	Хүчин	1	2	100	100	2	3	100	100
	Танхай	27	19	81.8	-29.6	15	23	94.7	4.7
	Булаалт	4	3	33.3	-25	3	2		100
	Хулгай	190	161	43.4	-15.3	191	170	36.7	0.9
	ББМГУ	91	79	83.3	-13.2	75	91	100	31.6
	Дээрэм	13	9	57.1	-30.7	11	9	77.8	11.1
	ТХХАББАЖЗ	32	16	100	-50	15	8	100	46.6
	Бусад	78	74	57.5	-5.1	27	33		22.2
	Бүгд	536	473	54.9	-11.8	365	356	51	2.8

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ

Тус тасгийн алба хаагчдын гудамж замд хийсэн хяналт шалгалтаар 2017 оны 4-р сард нийт **11065** зөрчил илрүүлсэнээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27.1 дэх хэсгийн заалт зөрчин согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон **206**, мөн хуулийн 31.2.3, 32.2, 43.2, 52.1 дэх хэсгүүдэд заасан зөрчилтэй 33 тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1 дэх хэсэгт заасан зөрчилтэй 0, улсын дугаарын хязгаарлалт **799**, бүрэн бус **321**, хамгаалах бүс хэрэглээгүй **932**, нийт **9807** жолоочийг **238.800.000** төгрөгөөр торгож ажиллав. Замын Цагдаагийн газар болон бусад албадаас зарлагдсан 18 дугаарыг илрүүлэн ерөнхий жижүүрт хүлээлгэн өгсөн. Цагдаагийн шалгах төхөөрөмж ашиглан 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ASAP санд бүртгэлтэй сэжигтэн яллагдагч тээврийн хэрэгсэл ашиглан хөдөлгөөнд оролцож байсан 6, Цагдаагийн нийтлэг үүргээр 4 зөрчил тус тус илрүүлсэн.

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, ГАМШИГ

2017 оны 4 дүгээр сарын байдлаар хэлтсийн Гал унтраах, аврах 10 дугаар анги нь 116 удаагийн 2784 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гал түймрийн дуудлагаар 279 удаа гарснаас 175 удаа гал түймэр дээр нийт 68.3 цаг ажиллаж 310.9 тонн ус, шатах тослох материал дизель түлш 11.1 мянган литр буюу 18.5 сая төгрөгийг зарцуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 606.4 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, 77 гал түймрийг иргэд унтрааж, 14 гал түймэр өөрөө унтарч, 73 байшин, барилга, 5 хүний амь насыг авран хамгаалсан байна.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ


Тус хэлтэс нь 2017 оны 04 сарын байдлаар нийт 2613 нэгжид шалгалт, 519 нэгжид хяналт хийж гүйцэтгэсний 80.0 хувь нь ААНБ-г, 20.0 хувь нь иргэнийг хамарсан байна.

Хүснэгт 18. Хяналт, шалгалт, зөрчил, торгуул шийтгэвэрийн мэдээ, тасгаар


Үзүүлэлт		Нийт дүн	ЭМБХАБХ-ын тасаг	БОДБХНХХ-ын тасаг
Хяналт	ААНБ	310	279	31
	Иргэн	209	201	8
	Дүн	519	480	39
Шалгалт	ААНБ	2198	1459	739
	Иргэн	415	367	48
	Дүн	2613	1826	787
Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил	Нийт илэрсэн	1392	1215	177
	Арилгасан	696	604	92
Торгууль, шийтгэвэр	Тоо	171	148	23
	Үнийн дүн мян.төг	38640	30650	7990
Зөвлөн туслах сургалт, сурталчилгаа	ААНБ	334	247	87
	Иргэн	100	64	36
	Дүн	434	311	123

Энэ хугацаанд нийт 1392 зөрчил илэрсний 696 буюу 50.0 хувийн зөрчлийг арилгасан ба нийт 171 торгууль, шийтгэвэрт нийт 38.64 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Зураг 12. Хийсэн хяналт тоо, тасгаар



Зураг 13. Хийсэн шалгалтын тоо, тасгаар



СОЁЛ УРЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2017 оны 4-р сарын байдлаар Чингэлтэй дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс:

- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж, 5242 хүүхэд багачууд, иргэд хамрагдсан байна.

ХҮҮХЭД, ГЭР БҮЛ ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв нь 2017 оны 4-р сард нийт 600 хүн, 30 гэр бүлд хүрч ажилласан байна.

Хүснэгт 19. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалалын чиглэлээр хийсэн ажил

№	Үйл ажиллагааны чиглэл	Зохион байгуулагдсан ажил	Хамрагдсан хүний тоо
1	Хүүхдийн тусламжийн утас 108- аас	Ирсэн дуудлагын тоо 4-р сард- 24	22 хүүхэд
2	Ажилласан кейс	Нийт 24үүнээс: Бие махбодийн хүчирхийлэл-6 Бэлгийн хүчирхийлэл-1 Үл хайхрах хүчирхийлэл-9 Шинжээчийн дүгнэлт-3 Сэтгэл санааны хүчирхийлэл-6 Нас барсан-2 тус тус гарсан байна.	22 хүүхдийн эрхийг хамгаалан ажилласан.

3	Хүүхэд хамгааллын чиглэлээр	1. 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, ДЗМОУБ-ын Хайлааст ОНХХ, Монгол өрх ТББ-тай хамтран “Хүчирхийллийг таслан зогсооё” кейс хэлэлцүүлгийг 3 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгуулж, 1-19 дүгээр хороодын Засаг дарга, хэсгийн байцаагч, нийгмийн ажилтнууд, ГБХЗХХ-ийн ажилтнууд оролцсон. 2. ЭМН, ХХҮХ-тэй хамтран хороодын архины хамааралтай зорилтот бүлгийн 10-н өрхийг сонгон Эрүүл мэнд, сэтгэц нарколог, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөдөлбөрт хамруулах үйл ажиллагаан зохион байгуулан ажиллаж байна. 3. ГБХЗХХэлтэс ГХУСАЗСЗ, ЗДТГ, ДЗМОУБ, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран хамтарсан багийн “Хамтын ажиллагаа” 3-н сарын аяны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.	гэр бүл-20
4	Гэр бүл, залуучуудын хөгжлийн чиглэлээр	1. 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр “Угийн бичиг” хөтөлдөг айл өрхийг нэмэгдүүлэх, цус ойртолтоос сэргийлэх, энэ тухайд иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол” сэдэвт сургалтыг ЧД-ийн 18 дугаар хорооны Иргэний танхимд тус хорооны зорилтот бүлгийн 5 гэр бүлийн төлөөллийг хамруулан зохион байгуулсан. 2. Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо Чингэлтэйн 6-р гудамж 156 тоотод оршин суух Х.Соёлмаагийн нэхэмжлэлтэй Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо Дэнжийн 37-р гудамж 492 тоотод оршин суух Г.Энхтүвшинд холбогдох хүүхдийн асрамж тогтоолгож, тэтгэлэг гаргуулах иргэний хэрэгт хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх зан байдал, нөхцөл боломж зэрэг асуудлын хүрээнд шинжээчийн багийн дүгнэлт гарган Иргэний хэргийн анхан шатны нэгдүгээр шүүхрүү 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн. 3.НҮБ-ын Хүн амын сан /UNFPA/, Жи Си Ай Прогрес / JCI progress/ салбар байгууллага, Чингэлтэй дүүргийн Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран “1000 идэвхтэй иргэн-2017” хөгжлийн төслийг Чингэлтэй дүүргийн 15, 16, 18 хороонд хэрэгжүүлэхээр болсон. Энэхүү төсөл нь тухай дүүрэгт бизнес эрхлэх сонирхол бүхий 18-35 насны залуучуудад бизнес төсөл амжилттай явуулах мэдлэг чадвар олгох, залуучуудад	гэр бүл-10 Залуучууд-48

		нийтлэг тулгамддаг тодорхой асуудлын хүрэээд шинэлэг бүтээлч шидлийг хамтран тодорхойлох хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахад уг арга хэмжээний зорилго оршино. Төслийн эхний үе шат болгож “Өгөөж чихэр боов” ХХК-ны захирал Н.Түмэнгэрэлийг урьж “Миний бизнесийн гараа” сэдэвт лекц ярилцлагыг 2017 оны 04 дүгээр сарын 21-нд Чингэлтэй дүүргийн 16-р хорооны иргэний танхимд амжилттай зохион байгууллаа. Сургалтанд 15, 16, 18-р хорооны 18-35 насны 48 идэвхитэй иргэн хамрагдсан. Цаашид шилдэг бизнес төслийг шалгаруулан зохион байгуулагчдын зүгээс санхүүжүүлэх юм. Тус төсөл нь 2017 оны 11-р сар хүртэл үргэлжилэн ажиллахаар болсон. 4. ХНХ-н яамны харьяа Хүүхдийн төлөө байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг 2017 оны 04 дүгээр сарын 26-нд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан. Тус өдөрлөгт ЧД-н ГБХЗХХ-с ГБХТТ, ХЭТХ, ХХТХ, хуулийг иргэдэд сурталчлах, зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн 10 төрлийн танилцуулга мэдээллийг хүргэж нийт 280 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 5. “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг”, “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 2017 оны 04 дүгээр сарын 30-нд Тусгаар тогтнолын талбай, ЧД-н 9, 10-р хороодод батлагдсан удирдамж төлөвлөгөөний дагуу ажилласан.	Иргэн-280 Иргэн-250
5	Мэдээлэл судалгааны чиглэлээр	2017.03.18-19 хооронд Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар, Иргэний боловсролын төвтэй хамтран "Залуучуудын утга учиртай оролцоог хангах нь" сэдэвт сургалтанд хэлтсийн ХГБХТ-ийн ажилтан М.Бат-Эрдэнэ оролцсон. Семинарт Нийслэлийн залуучуудын хөгжлийн газрын дарга, мэргэжилтэн, "Залуучуудын хөгжлийн хөтөлбөр" хэрэгждэг 11 аймаг, 3 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, мэргэжилтнүүд оролцлоо.	



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

WWW.1212.MN

WWW.UBSTAT.MN

WWW.CHINGELTEI.GOV.MN



Хянасан: Хэлтсийн дарга М.Түвшинтөр

Танилцуулга нэгтгэсэн:
мэргэжилтэн С.Ханд

И-мэйл хаяг: chingeltei@nso.mn

Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг,
Нийслэлийн төр захиргааны
III байр 401 тоот
Утас: 70113013
70130767
11-310767